



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ БАЙГУУЛАМЖ ТӨААТҮГ-ЫН  
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/56/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Д.Энхдалай  
Утас: 261885 Цахим хаяг: [enkhdalaid@audit.gov.mn](mailto:enkhdalaid@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Б.Эрдэнэзул  
Утас: 261628 Цахим хаяг: [erdenezulb@audit.gov.mn](mailto:erdenezulb@audit.gov.mn) Аудитыг  
гэрээгээр гүйцэтгэсэн "Уваа уул" аудит ХХК Захирал  
Ч.Мөнхтуяа  
Утас: 99108763 Цахим хаяг: [uwaauul.audit@gmail.com](mailto:uwaauul.audit@gmail.com)

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Материаллаг байдал.....	9
4. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	10
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	10
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	10
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	12
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
8. Аудитын илрүүлэлт.....	14
8.1 Төлбөрийн акт.....	14
8.2 Албан шаардлага.....	14
8.3 Зөвлөмж.....	14
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	15
10. Хавсралт: Төлбөрийн акт, албан шаардлага.....	17

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ШТШАБ	Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/614  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ  
БАЙГУУЛАМЖ ТӨААТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ Г.ГАНСҮХ ТАНАА

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 103.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа эсвэл нийтээрээ материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

#### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Тайлант онд нийт орлогыг 3,046.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 2,021.1 сая төгрөгөөр, ашгийг 1,025.3 сая төгрөг байхаар төлөвлөгөөг баталсан байна. Гүйцэтгэлээр 4,817.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,905.3 сая төгрөгийн зардал гарган, 2,911.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

## Бусад асуудал

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

## Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	968,684,126.75	1,401,789,382.69
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	159,807,901.61	136,122,443.96
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	5,054,932,656.98	6,856,404,752.77
1.1.6	Бараа материал	215,373,672.06	260,832,219.43
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	4,377,272.73	31,922,547.73
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>6,403,175,630.13</b>	<b>8,687,071,346.58</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	12,541,898,674.84	12,667,709,150.82
1.2.2	Биет бус хөрөнгө	1,431,920,002.16	1,380,021,532.52
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>13,973,818,677.00</b>	<b>14,047,730,683.34</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>20,376,994,307.13</b>	<b>22,734,802,029.92</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	2,549,622.00	8,641,978.00
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.3	Татварын өр	8,323,881.87	0.00
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	0.00	28,056,925.85
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>10,873,503.87</b>	<b>36,698,903.85</b>
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	107,532,962.97	107,532,962.97
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	107,532,962.97	107,532,962.97
2.2	Өр төлбөрийн нийт дүн	118,406,466.84	144,231,866.82
2.3.1	Төрийн өмч	15,362,339,049.32	15,362,339,049.32
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	282,110,305.92	282,110,305.92
2.3.9	Хуримтлагдсан ашиг	4,614,138,485.05	6,946,120,807.86
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>20,258,587,840.29</b>	<b>22,590,570,163.10</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>20,376,994,307.13</b>	<b>22,734,802,029.92</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр )</b>	<b>4,310,469,060.05</b>	<b>4,169,440,269.97</b>
2	Борлуулалтын өртөг	0.00	0.00
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>4,310,469,060.05</b>	<b>4,169,440,269.97</b>
5	Хүүгийн орлого	321,415,828.43	647,225,895.72
8	Бусад орлого	1,500,000.00	350,000.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,534,935,919.13	1,805,176,568.30
12	Бусад зардал	3,483,560.00	100,124,920.00
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>3,094,965,409.35</b>	<b>2,911,714,677.39</b>
19	Орлогын татварын зардал	309,836,540.94	301,219,467.74
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>2,785,128,868.41</b>	<b>2,610,495,209.65</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>2,785,128,868.41</b>	<b>2,610,495,209.65</b>
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>2,785,128,868.41</b>	<b>2,610,495,209.65</b>

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>15,362,339,049.32</b>	<b>282,110,305.92</b>	<b>2,090,606,699.60</b>	<b>17,735,056,054.84</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	15,362,339,049.32	282,110,305.92	2,090,606,699.60	17,735,056,054.84
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	2,785,128,868.41	2,785,128,868.41
<b>2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>15,362,339,049.32</b>	<b>282,110,305.92</b>	<b>4,614,138,485.05</b>	<b>20,258,587,840.29</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	15,362,339,049.32	282,110,305.92	4,614,138,485.05	20,258,587,840.29
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	278,512,886.84	278,512,886.84
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	2,610,495,209.65	2,610,495,209.65
<b>2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>15,362,339,049.32</b>	<b>282,110,305.92</b>	<b>6,946,120,807.86</b>	<b>22,590,570,163.10</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>4,855,308,696.00</b>	<b>4,609,905,413.00</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,849,165,981.00	4,586,698,312.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	6,142,715.00	23,207,101.00
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>1,754,853,416.03</b>	<b>2,028,603,013.98</b>
1.2.1	Ажилдагсад төлсөн	510,023,158.00	676,560,262.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	144,631,155.90	199,445,701.74
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	88,659,716.58	57,052,759.57
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	61,136,872.20	54,646,907.90
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	58,034,589.00	65,080,061.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	807,356,247.16	697,676,614.43
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,347,960.00	118,800.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	83,663,717.19	278,021,907.34
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,100,455,279.97	2,581,302,399.02
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>321,415,828.43</b>	<b>1,482,225,895.72</b>
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	835,000,000.00
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	321,415,828.43	647,225,895.72
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>5,363,073,980.21</b>	<b>3,351,910,151.96</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	241,248,141.41	690,232,601.63
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	66,893,181.82	25,205,454.54
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	5,054,932,656.98	2,636,472,095.79
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(5,041,658,151.78)	(1,869,684,256.24)
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>261,597,082.96</b>	<b>278,512,886.84</b>
3.2.4	Төлсөн ногдол ашиг	261,597,082.96	278,512,886.84
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(261,597,082.96)	(278,512,886.84)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(2,202,799,954.77)	433,105,255.94
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>3,171,484,081.52</b>	<b>968,684,126.75</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>968,684,126.75</b>	<b>1,401,789,382.69</b>



## 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<u>Бүтээгдэх үйлдвэрлэлт, борлуулалт</u>						
	Газрын тосны бүтээгдэхүү	мянган тонн	117.8	72.0	126.7	(54.7)	176.0
	Газрын тосны бүтээгдэхүү	мянган тонн	17.0	11.3	18.8	(7.5)	166.7
2	Нийт орлого	мянган төгрөг	4,633,384.9	3,046,363.5	4,817,016.2	(1,770,652.7)	158.1
	Үүнээс: Цэвэр	мянган төгрөг	4,301,318.1	2,446,363.5	4,156,344.3	(1,709,980.8)	169.9
	Дансны хүү, ГТБ шинжилгээний орлого	мянган төгрөг	332,066.8	600,000.0	660,671.9	(60,671.9)	110.1
3	Нийт зардал	мянган төгрөг	1,538,419.5	2,021,087.0	1,905,301.5	115,785.5	94.3
	Үүнээс: Удирдлагын	мянган төгрөг	276,473.7	458,906.3	411,265.2	47,641.1	89.6
4	Татварын өмнө ашиг	мянган төгрөг	3,094,965.4	1,025,276.5	2,911,714.7	(1,886,438.2)	284.0
5	Цэвэр ашиг /алдагдал/	мянган төгрөг	2,785,128.9	922,748.8	2,610,495.2	(1,687,746.4)	282.9
6	<u>Т ө с в и й н т ө л б ө р т</u>	мянган төгрөг	951,064.0	552,738.6	831,931.4	(279,192.8)	150.5
7	Төрийн өмчийн	мянган төгрөг	261,597.1	284,052.0	278,512.9	5,539.1	98.0
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	32	35	33	2.0	94.3
9	Нийт цалингийн сан	мянган төгрөг	584,703.1	882,322.6	802,689.2	79,633.4	91.0
10	Нэг ажиллагчийн	мянган төгрөг	1,522.7	2,100.8	2,027.0	73.8	96.5
11	Борлуулалтын нэг төгрөгт ногдох	төгрөг	0.33	0.66	0.40	0.3	59.62
12	Хөрөнгө оруулалт	мянган төгрөг	308,141.3	1,676,385.7	715,438.1	960,947.6	42.7
13	Нийт авлага	мянган төгрөг	159,807.9	-	136,122.4	(136,122.4)	
14	Нийт өглөг	мянган төгрөг	118,406.5	6,902.7	144,231.9	(137,329.2)	2,089.5
	Үүнээс: Богино хугацаат өр	мянган төгрөг	10,873.5	6,902.7	36,698.9	(29,796.2)	531.7

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг үнэлэх ашиглах жилийг сунгах саналыг бэлтгэж холбогдох байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Уваа уул Аудит ХХК-ийн аудитор Б.Буяндэлгэр, аудиторын туслах Э.Номинчулуун, Г.Сампилмаа нар гүйцэтгэж, чанар хяналтыг захирал Ч.Мөнхтуяа хэрэгжүүлсэн.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлангаа Уваа уул аудит ХХК-д 2022 оны 02 дүгээр сарын 15-ны өдрийн 31 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Дотоод хяналт

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж байхгүй бөгөөд тайлант хугацаанд УУХҮЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, ТӨБЗГ-ын хууль эрх зүй, хяналт, дотоод аудитын хэлтсээс шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

#### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын 2020 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлан, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 1,538.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 15.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4. Санхүүгийн тайлангийн тодруулга**

##### **4.1 Байгууллагын үйл ажиллагаа**

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын зорилго нь “Төмөр замаар тээвэрлэн нийлүүлж байгаа газрын тосны бүтээгдэхүүнийг Монголын вагон цистерн болон автоцистернд шилжүүлэн ачих, хадгалах, үйл ажиллагааг тасралтгүй явуулах, газрын тосны эх үүсвэрийг нэмэгдүүлэх, цаашид тус байгууламжийн ашиглалтыг мэргэжлийн удирдлагаар хангах”-д оршино.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- ✓ Газрын тосны бүтээгдэхүүнийг шилжүүлэн ачих, хадгалах, ажлыг гүйцэтгэх;
- ✓ Газрын тосны бүтээгдэхүүнийг шилжүүлэн ачих тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллээр холбогдох байгууллагыг хангах;
- ✓ Олон улсын чанарын стандартад нийцсэн газрын тосны бүтээгдэхүүнийг зохих журмын дагуу импортлох;
- ✓ Үйлдвэрийн газар нь хөрөнгө оруулалт хийх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, судалгаа хийх;
- ✓ Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;
- ✓ Хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа эрхлэх.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ТӨААТҮГ статустай байна. Өмчийг 100.0 хувь төр эзэмшиж байна.

##### **4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин**

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ыг Засгийн газрын 2009 оны 347 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын удирдлагыг ТӨБЗГ хэрэгжүүлдэг бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлгүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль
- ✓ Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль
- ✓ Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол
- ✓ ЗГ-ын 2021 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол

##### **4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого**

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	968,684.1	1,401,789.3	433,105.2
Бусад санхүүгийн хөрөнгө	5,054,932.6	6,856,404.7	1,801,472.1
Авлага	159,807.9	136,122.4	(23,685.4)
Урьдчилгаа	4,377.3	31,922.5	27,545.3
Бараа материал	215,373.3	260,832.2	45,458.5
Үндсэн хөрөнгө	12,541,898.3	12,667,709.1	125,810.50
Биет бус хөрөнгө	1,431,920.0	1,380,021.5	(51,898.45)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>20,376,994.3</b>	<b>22,734,802.0</b>	<b>2,357,807.7</b>
Богино хугацаат өглөг	10,873.5	36,698.9	25,825.4
Урт хугацаат өглөг	107,532.9	107,532.9	0.0
Эздийн өмч	20,258,587.8	22,590,570.2	2,331,982.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>20,376,994.3</b>	<b>22,734,802.0</b>	<b>2,357,807.7</b>

Мөнгөн хөрөнгө 433.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант хугацааны орлого өссөнөөс шалтгаалсан байна. Кассадаа 19.7 сая төгрөгийн бэлэн мөнгөний үлдэгдэлтэй гарсан байна. Банк дахь харилцах дансанд 1,382.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Бусад санхүүгийн хөрөнгө дансны үлдэгдэл 1,801.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь орлогыг хадгаламжийн дансны өсөлтөөс шалтгаалсан байна. Голомт банканд 3,500.0 сая төгрөг, Хас банканд 237.0 сая төгрөг, Худалдаа хөгжлийн банканд 3,119.4 сая төгрөг нийт 6,856.4 сая төгрөгийн хадгаламж байна.

Авлагын дансны үлдэгдэл 23,685.4 сая төгрөгөөр буурсан нь түрээсийн авлагаа барагдуулсан байна.

Авлагын дансны үлдэгдэлд ААНОАТ-ын авлага 41.4 сая төгрөг, НӨАТ-ын авлага 90.6 сая төгрөг байна.

Тайлант онд аудитын ажлын төлбөрт 15.3 сая төгрөг, Вагон-эстекадны дээврийн засварын ажлын төлбөрт 13.8 сая төгрөг, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх ажилд 2.7 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн байна. Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй 2020 онд шилжүүлсэн 2.7 сая төгрөгийн ажил харьяалах яамнаас хүчин төгөлдөр болж баталгаажуагүй шалтгаанаас дуусаагүй, гүйцэтгэлийг хүлээн аваагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 260.8 сая төгрөг болж 45.4 сая төгрөгөөр өссөн нь хангамжийн материалын худалдан авалтаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 125.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 715.4 сая төгрөгийн ууршуулах талбай, бетонон хашаа, вакум систем, шатахууны шавхалтын насос зэрэг машин тоног төхөөрөмжийг нэмж худалдан авснаас шалтгаалсан бөгөөд Энэ нь төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 637, 2021 оны 10 дугаар сарын 05-ны А-1/1583, мөн оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А-1/2103 дугаар шийдвэрийг үндэслэсэн хийгдсэн байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 36.7 сая төгрөг болж 25.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 28.0 сая төгрөгийн тендерийн ажлын баталгааны өглөг, 8.6 сая төгрөгийн цахилгааны өглөг үүссэнтэй холбоотой байна.

Эздийн өмч 2,332.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант хугацааны 2,610.5 сая төгрөгийн цэвэр ашгийн өсөлтөөс шалтгаалсан байна.

#### 4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 637 дугаар тогтоолоор Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот

түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 3,046.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 2,021.1 сая төгрөгөөр, ашгийг 1,025.3 сая төгрөг байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын 29 арга хэмжээнд 1,676.4 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 4,817.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,905.3 сая төгрөгийн зардал гарган, 2,911.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 4,817.0 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,770.6 сая төгрөг буюу 58.1 хувиар давсан нь бүтээгдэхүүн шилжүүлэн ачилт, хадгалалтын үйл ажиллагаа өссөнөөс голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,905.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 115.7 сая төгрөг буюу 15.3 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь цалин, удирдлагын зардлуудыг хэмнэсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 29 нэр төрлийн 11 ажилд өөрийн эх үүсвэрээс 715.4 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг /алдагдал/ 2,610.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,687.7 сая төгрөгөөр илүү байгаа нь орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн нь нөлөөлж байна.

ТӨБЗГ-ын 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 228 тоот шийдвэрийн дагуу тайлант онд 278.5 сая төгрөгийн ногдол ашиг буюу ашгийн 10 хувийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Тайлант онд Орон нутгийн байгууллагад 100.0 сая төгрөгийн хандив өгч төсвөөс гадуур зардал гаргасан байна.

## **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ нь тайлант онд нийт 19,192.5 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 3,254.4 сая төгрөгийн 13 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

### **5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Дээрх хуулиас гадна, тухайлбал Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгасан.

Тайлант онд худалдан авах ажиллагааны цахим системд 14 удаагийн 1,250.9 сая төгрөгийн тендерийн мэдээллээ байршуулж “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ыг мөрдөж ажилласан байна.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тус газрын захирлын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/25 дугаар тушаалаар урамшуулал олгохоор шийдвэрлэж, 21 ажилтанд 67.1 сая төгрөгийг бодож олгосон байна.

Энэ тогтоолын 1.3. “төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, ... ”, заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. ТӨБЗГ-аас шийдвэртэй боловч ЗГ-аас авч хэрэгжүүлсэн хэмнэлтийн горимыг зөрчин 11.0 сая төгрөгийн тавилга эд хогшил, 5.5 сая төгрөгийн монгол гэр худалдан авсан байна. Энэ тогтоолын 1.4. “энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн ТБОНӨХБАҮХАТ хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн, шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, ажилтнуудад урамшуулал олгосон, хөрөнгө худалдан авсан зэрэг нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын холбогдох заалтуудтай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

## 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 104.3 сая төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснийг аудитын явцад залруулж, зөрчлийг арилгасан байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 16.7 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 9.6 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгснөөс албан шаардлага 50.0 хувь, зөвлөмж 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	2	16,700.0	1	16,700.0	1	-	50.0
Зөвлөмж	1	9,600.0	1	9,600.0	-	-	100.0
Нийт дүн	3	26,300.0	2	26,300.0	1	-	75.0

Тайлант онд байгууллагын нэр бүхий 31 ажилтанд 16.7 сая төгрөгийн шагналыг хавтгайруулах олгосон зөрчилд өгсөн албан шаардлын хэрэгжилт хангалтгүй байна. Шилэн дансны нэгдсэн системд 13 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан зөрчил давтан гаргасан тул хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант хугацааны эцэст шинээр авлага үүссэн, байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байсан тул дараагийн аудитаар горим сорил хэрэгжүүлж баталгаажуулахаар шийдвэрлэв.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн алдаа зөрчлөөс 103.4 төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 103.4 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 15.4 сая төгрөгийн түвшнээс 88.0 сая төгрөгөөс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 8.1 Төлбөрийн акт

ТӨБЗГ-ын шийдвэргүйгээр 6 дугаар сараас эхлэн сар бүр 25.0 хувиар урамшуулал тооцон, нийт 3.4 сая төгрөгийг авсан нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 1.2 "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно", 1.2.1 "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна. ТӨБЗГ-тай байгуулсан контрактын 4.2 дахь заалт "...урамшуулал олгох эсэх асуудлыг ТӨБЗГ шийдвэрлэнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажлын үр дүнг тооцоогүй байхад урамшуулал олгосон тул төлбөрийн акт тогтоох.

### 8.2 Албан шаардлага

Төсвийн байгууллагад 2021 оны 12 дугаар сарын 21-ны өдөр 100 сая төгрөгийн хандив өгсөн нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10. "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно", гэж заасныг зөрчсөн, "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 25.10 дахь заалтыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлэх.

### 8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 682.5 сая төгрөгийн хөрөнгийг ашиглах хугацааг сунгах, дахин үнэлж саналаа ТӨБЗГ-т хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" 7.1-д "төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

ТӨБЗГ-аас ашиглах жил, үнэ шинэчлэн тогтоох зөвшөөрөл авч тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж			
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн асуудлаар</b>																		
1	ШТШАБ ТӨААТУ Г	АХГ- 2022/56/Н А-СТА- ТӨА	ТӨБЭЗГ-ын шийдвэргүйгээр захирал 6 дугаар сараас эхлэн сар бүр 25.0 хувиар урамшуулал тооцон, нийт 3.4 сая төгрөгийг авсан байна.	Ажлын үр дүнг тооцоогүй байхад урамшуулал олгосон тул төлбөрийн акт тогтоох.	1	3,443.0		1	3,443.0									
2	ШТШАБ ТӨААТУ Г	АХГ- 2022/56/Н А-СТА- ТӨА	Замын үлд сумын ЗДТГ-т 12 дугаар сарын 21-ны өдөр 100 сая төгрөгийн хандив өгсөн	Төсвийн тухай хуулийн 25.10 дахь заалтыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлэх	1	100,000.0		1	100,000.0									
3	ШТШАБ ТӨААТУ Г	АХГ- 2022/56/Н А-СТА- ТӨА	Байгууллагын үйл ажиллагаанд хэвийн ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 682.5 сая төгрөгийн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоолгоогүй байна.	ТӨБЭЗГ-аас ашиглах жил, үнэ шинэчлэн тогтоох зөвшөөрөл авч тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.	1	-										1		
					3	103,443.0	0	0	1	3,443.0	1	100,000.0	0	0	1	0	1	0
<b>Санхүүгийн тайлангийн аудитын дүн</b>																		
<b>Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал</b>																		
1	ШТШАБ ТӨААТУ Г	АХГ- 2022/56/Н А-СТА- ТӨА	Тайлант онд нийт 19,192.5 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 3,254.4 сая төгрөгийн 13 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.	Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.	1	-								1	-			
2	ШТШАБ ТӨААТУ Г	АХГ- 2022/56/Н А-СТА- ТӨА	Тус газрын захирлын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/25 дугаар тушаалаар урамшуулал олгохоор шийдвэрлэж, 21 ажилтанд 67.1 сая төгрөгийг бодож олгосон байна.	Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох	1	67,081.4		1	67,081.4									
3	ШТШАБ ТӨААТУ Г	АХГ- 2022/56/Н	МУЗГ-аас авч хэрэгжүүлсэн хэмнэлтийн горимыг зөрчин 11.0 сая төгрөгийн тавилга эд	Засгийн газрын 43 дугаар тогтоолыг зөрчсөн тул албан шаардлага өгөх.	1	16,500.0					1	16,500.0						







ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 132/А0150053  
АХГ-2022/56/НА-СТА-ТӨА  
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэргүйгээр захирал 6 дугаар сараас эхлэн сар бүр 25.0 хувиар урамшуулал тооцон нийт 3,443,000.00 төгрөгийг авсан байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 1.2 "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно", 1.2.1 "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай байгуулсан контрактын 4.2 дахь заалт "...урамшуулал олгох эсэх асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар шийдвэрлэнэ", гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ажлын үр дүнг тооцоогүй байхад урамшуулал олгосон нийт 3,443,000.00 /Гурван сая дөрвөн зуун дөчин гурван мянган/ төгрөгийг буруутай албан тушаалтнуудаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар't ирүүлэхийг Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын захирал Г.Гансүх, ерөнхий нягтлан бодогч Б.Дэлгэрдалай нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

УВАА УУЛ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

Ч.МӨНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

1019120396

\\10.10.10.20\BI-chig\_Nereg\Akt\2022\0315 Auditin 2 Газар-66.Docx

0001090308



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 133/А.0150053

Улаанбаатар хот

АХ Г-2022/56/НА-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус газрын захирлын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/25 дугаар тушаалаар урамшуулал олгохоор шийдвэрлэж, 21 ажилтанд 67,081,000.00 төгрөгийг бодож олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол 1.3. "төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь үялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, ...", гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Засгийн газрын 43 дугаар тогтоолыг зөрчиж, урамшуулал хавтгайруулан олгосон нийт 67,081,000.00 /жаран долоон сая наян нэгэн мянган/ төгрөгийг буруутай албан тушаалтнуудаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын захирал Г.Гансүх, ерөнхий нягтлан бодогч Б.Дэлгэрдалай нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

УВАА УУЛ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

Ч.МӨНХТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 588/А0150053

Улаанбаатар хот

АХГ-2022/56/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шийдвэртэй боловч Засгийн газраас авч хэрэгжүүлсэн хэмнэлтийн горимыг зөрчин, 11,000,000.00 төгрөгийн тавилга эд хогшил, 5,500,000.00 төгрөгийн монгол гэр худалдан авсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4. "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй", гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын захирал Г.Гансүх, ерөнхий нягтлан бодогч Б.Дэлгэрдалай нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭНХДАЛАЙ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.МӨНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэн дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

\\10.10.10.20\Bic\Bic\_Khereg\Alban\_Shaardlaga\2022\0315\_Auditin\_2\_Gazar-267.Docx

0001021534



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 589/А0150053

Улаанбаатар хот

АХГ - 2022/56/НА-СТА - ТӨА

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн шилэн дансны цахим системд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, ил тод байдлыг хангаж ажиллах албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, тайлант онд зөрчлийг давтан гаргаж, байгууллагын шилэн дансны цахим мэдээллийн санд байршуулбал зохих 149 мэдээллээс 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "Тогтсон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 4.1.4 "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3."Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, ил тод байдлыг ханган ажиллаж, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын захирал Г.Гансүхэд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭНХДАЛАЙ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.МӨНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-204230

9006109  
10.10.10.20\Bichig\Chereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-266.Docx  
0019120396

0001081532



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 581/А0150053

Улаанбаатар хот

АХС-2022/56/НА-СТА-ТӨА  
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн байгууллагад 12 дугаар сарын 21-ний өдөр 100,000,000.00 төгрөгийн хандив өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10 "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Бусдад хандив тусламж өгөхгүй байх, зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын захирал Г.Гансүх, ерөнхий нягтлан бодогч Б.Дэлгэрдалай нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

Ч.МӨНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264 350

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-265.Docx

0001081530







